БАТЛАВ:

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН САНХҮҮ, АЖ АХУЙН АЛБАНЫ ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

У.ЭНХТӨР

"ПЕТРОСТАР" ХХК-Н ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

С.ЭНХ-АМГАЛАН

# ТОС, ТОСЛОХ МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

2017 оны 08 дугаар сарын 11 -ны өдөр Улаанбаатар хот

№ 2017/a/16

Энэхүү гэрээг нэг талаас "Петростар" ХХКомпани /цаашид нийлүүлэгч гэнэ/, нөгөө талаас Цагдаагийн ерөнхий газар /цаашид худалдан авагч гэнэ/, /хамтад нь талууд гэнэ/ дараах гэрээг байгуулав.

## Нэг. Гэрээний агуулга

1.1. Монгол Улсын иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон Нийлүүлэгч, Худалдан авагч нарын хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

1.2. Худалдан авагч нь нийлүүлэгчийн тендерээр ирүүлсэн тос, тослох материал (цаашид бараа гэнэ)-ын үнийг хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

1.3. Худалдан авагч нь барааны нийлүүлэлтийг улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

1.4. Нийлүүлэгч нь хавсралтад дурдсан нэр, төрлийн барааг 2017 оны 08 дугаар сарын 15-ны өдрөөс 2018 оны 08-р сарын 15-ны өдрийн хооронд, нийт нийлүүлэх тос, тослох материалыг 4 хуваан улирал бүр нийлүүлнэ.

1.6. Тос, тосолгооны материал нийлүүлэх жагсаалтыг гэрээний хавсралтад тусгана.

## Хоёр. Нийлүүлэгчийн эрх, үүрэг

2.1. Нийлүүлэгч нь худалдан авагчид Монгол Улсад хүлээн зөвшөөрөгдсөн чанар, стандартын шаардлага хангасан тос, тосолгооны материалыг худалдахаар тохиролцов.

2.2. Нийлүүлэгч нь тос, тосолгооны материалыг Цагдаагийн ерөнхий газрын Авто баазын тосны агуулахад захиалгат хуваарийн дагуу нийлүүлнэ.

## Гурав. Худалдан авагчийн эрх, үүрэг

3.1. Худалдан авагч нь тос, тосолгооны материалыг хүлээн авах албан тушаалтны нэр, гарын үсгийн баталгааг албан бичгээр нийлүүлэгчид өгөх ба энэ нь гэрээний нэг хэсэг болно.

3.2. Худалдан авагч нь барааг гэрээний хугацаанд нийлүүлэхийг шаардах эрхтэй.

3.3. Худалдан авагч нь чанарын шаардлага хангасан тос, тосолгооны материал нийлүүлэхийг шаардах эрхтэй.

3.4. Худалдан авагч нь тос, тосолгооны материалын тоо хэмжээ, үнийн дүнд тааруулан шаардлага бүхий маркийн тос, тосолгооны материалыг нийлүүлэгч байгууллагатай харилцан тохиролцсоны үндсэн дээр нийлүүлж болно.

## Дөрөв. Төлбөрийн нөхцөл, хариуцлага

4.1. Нийлүүлэгч нь худалдан авагчид авсан тос, тослох материалын нэр төрөл, тоо хэмжээний дагуу үнийн дүнг нэхэмжилнэ.

4.2. Худалдан авагч төлбөрийг улирал бүрийн нийлүүлэлтийн дараа ажлын 10 хоногийн дотор нэхэмжлэлийн дагуу төлнө.

4.3. Барааны үнэ нь 107,981,550 /Нэг зуун долоон сая есөн зуун наян нэгэн мянга таван зуун тавин/ төгрөг байна.

4.4. Гэрээний явцад үнэ тогтмол байна. Тос, тосолгооны материалын үнэ нийлүүлэгч талаас үл хамаарах буюу гаалийн үнэ, онцгой албан татвар, валютын ханш нэмэгдсэн тохиолдолд худалдан авагч талд албан бичгээр бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэн талаар мэдээлнэ. Энэ тохиолдолд талууд харилцан тохиролцож бүтээгдэхүүний тоо ширхэг болон гэрээний хавсралтад өөрчлөлт оруулж болно.

## Тав. Барааны чанар

5.1. Нийлүүлсэн бүтээгдэхүүний чанар нь тендерийн баримт бичигт заасан техникийн тодорхойлолтын дагуу Монгол улсын цаг агаарын нөхцөл, стандартад тохирсон байна.

5.2. Нийлүүлсэн бүтээгдэхүүний чанарыг худалдагч тал бүрэн хариуцна.

5.3. Тос, тослох материалын чанарын гэрчилгээ, лабораториор баталгаажуулсан бичиг баримтыг гэрээнд хавсаргах ба энэ нь гэрээний салшгүй хэсэг болно.

**Зургаа. Талуудын хариуцлага**

6.1. Нийлүүлэгч нь гэрээг биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол:

а/ Гэрээний нөхцөл зөрчсөнөөс учирсан хохирлыг худалдан авагчид нөхөн төлнө. Дутуу бэлтгэн нийлүүлсэн бол бэлтгэн нийлүүлээгүй бараа бүтээгдэхүүний үнийн дүнгийн 0,5 хувиар тооцон торгууль төлнө.

б/ Зохих ёсны чанар бүхий бараа бүтээгдэхүүн нийлүүлээгүй бол чанаргүй бараа бүтээгдэхүүний үнийг нөхөн төлөх ба дутуу нийлүүлсэн бүтээгдэхүүний хэмжээтэй адил хэмжээгээр торгууль төлнө.

в/ Нийлүүлэлтийн хугацаа хожимдуулсан бол Худалдан авагчид тийнхүү хугацаа хожимдуулсан өдрөөс эхлэн хоног тутам бараа бүтээгдэхүүний үнийн 0,5 хувиар тооцон алданги төлнө.

6.2. Худалдан авагч нь гэрээг биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол:

а/ Төлбөрийг нэхэмжлэхийн дагуу хугацаандаа төлөөгүй тохиолдолд төлөх ёстой хугацаанаас хойш өдрийн 0,5 хувь хүртэл алданги ноогдуулж тооцно.

**Долоо. Бусад зүйл**

7.1. Хоёр тал гэрээний биелэлтийг дүгнэж баталгаажуулна.

7.2. Энэхүү гэрээний явцад гарсан маргааныг талууд харилцан хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд хэрэв чадахгүйд хүрвэл шүүхээр шийдвэрлүүлнэ.

7.3. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болбол гэрээний хугацааг 2 сар хүртэл хугацаагаар сунгана. Давагдашгүй хүчин зүйлд байгалийн гамшиг, газар хөдлөлт, үер ус, дайн байлдаан, экспорт, импортын хориг, дээд газрын шийдвэр гэх мэт хамаарна.

7.4. Гэрээнд оруулах аливаа нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж, талуудын эрх бүхий төлөөлөгчид албан ёсоор баталгаажуулсан байна. Гэрээний нэмэлт, өөрчлөлт нь гэрээний нэг хэсэг бөгөөд гэрээний нэгэн адил хүчин төгөлдөр байна.

7.5. Гэрээг хоёр хувь үйлдэх бөгөөд хувиуд нь хуулийн адил тэнцүү эрхтэй байна. Гэрээний хавсралт нь гэрээний адил хүчин төгөлдөр байна.

7.6. Гэрээг аль нэг талын санаачилгаар цуцлахгүй бөгөөд хэрэв гэрээний үүргээ биелүүлэхээс татгалзвал түүнтэй холбогдож гарах бүх зардлыг буруутай тал нь бүрэн хариуцна.

ХЯНАСАН:

Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албаны
Санхүүгийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа

Н.Алтансүх

Худалдан авагчийг төлөөлж:
САНХҮҮ, АЖ АХУЙН АЛБАНЫ ХАНГАМЖИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА

Б.ЦЭНДБАЯР

Нийлүүлэгчийг төлөөлж:
"ПЕТРОВИС ОЙЛ" ХХК-Н САНХҮҮ ЭРХЭЛСЭН ЗАХИРАЛ

Ц.СЭРГЭЛЭН

"ПЕТРОСТАР" ХХК-Н ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

М.ХАТАНБҮҮВЭЙ

БОРЛУУЛАЛТЫН АХЛАХ МЕНЕЖЕР

Д.МӨНХ-ОД

БАЙГУУЛЛАГА ХАРИУЦСАН
АХЛАХ МЕНЕЖЕР

Э.МӨНХСҮХ

БАЙГУУЛЛАГА ХАРИУЦСАН
БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР

Н.ЭНХТУЛГА

ХУУЛЬЧ

Д.ТЭМҮҮЖИН

Улаанбаатар хот, Чингэлтэй
дүүргийн Самбуугийн гудамж-18
ЦЕГ-ын төв байр, 4-р давхар 404
тоот
Утас: 70118664
Факс: 70111873

Ерөнхий сайд Амарын гудамж 7,
Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар хот
Утас:330909, 88112735
Факс:311593
Данс:Голомт Банк 1103025864
ХХБанк 499137428

88117979
Мөнхзаяа

2017 оны 08 дугаар сарын 11 ний
өдрийн 2017/9/[illegible] дугаар гэрээний
хавсралт

УЛААНБААТАР ХҮРЭЭНИЙ ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГАД 2017-2018 ОНД БЭЛТГЭХ ТОС, ТОСЛОХ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ, ҮНИЙН ХУВААРЬ

| № | Багц | Тос, тослох материалын нэр | Хэмжих нэгж | Нийт, тоо /литр/ | Нэг бүрийн үнэ /төгрөг/ | Нийт үнэ /төгрөг/ |
|---|---|---|---|---|---|---|
| 2017 ОНЫ 08-Р САРЫН 15-НИЙ ӨДРӨӨС 11-Р САРЫН 15-НИЙ ӨДӨР | | | | | | |
| 1 | 1-р ээлж | Автомат Кропны тос | Литр | 383 | 8,300 | 3,178,900 |
| 2 | | Бензин масло | Литр | 1,034 | 5,950 | 6,152,300 |
| 3 | | Дизель масло | Литр | 450 | 7,750 | 3,487,500 |
| 4 | | Супер ТАП | Литр | 784 | 9,400 | 7,369,600 |
| 5 | | Делевол | Литр | 115 | 14,850 | 1,707,750 |
| 6 | | Солидол | Литр | 235 | 4,750 | 1,116,250 |
| 7 | | Тормозны шингэн | Литр | 132 | 4,300 | 567,600 |
| 8 | | Тосол | Литр | 1,031 | 2,400 | 2,474,400 |
| 9 | | Гидрийн шингэн | Литр | 181 | 3,200 | 579,200 |
| 10 | | Литол | Литр | 50 | 7,500 | 375,000 |
| Дүн: | | | | | | 27,008,500 |
| 2017 ОНЫ 11-Р САРЫН 15-НИЙ ӨДРӨӨС 2018 ОНЫ 02-Р САРЫН 15-НИЙ ӨДӨР | | | | | | |
| 1 | 2-р ээлж | Автомат Кропны тос | Литр | 383 | 8,300 | 3,178,900 |
| 2 | | Бензин масло | Литр | 1,034 | 5,950 | 6,152,300 |
| 3 | | Дизель масло | Литр | 450 | 7,750 | 3,487,500 |
| 4 | | Супер ТАП | Литр | 784 | 9,400 | 7,369,600 |
| 5 | | Делевол | Литр | 115 | 14,850 | 1,707,750 |
| 6 | | Солидол | Литр | 235 | 4,750 | 1,116,250 |
| 7 | | Тормозны шингэн | Литр | 132 | 4,300 | 567,600 |
| 8 | | Тосол | Литр | 1,031 | 2,400 | 2,474,400 |
| 9 | | Гидрийн шингэн | Литр | 181 | 3,200 | 579,200 |
| 10 | | Литол | Литр | 50 | 7,500 | 375,000 |
| Дүн: | | | | | | 27,008,500 |
| 2018 ОНЫ 02-Р САРЫН 15-НИЙ ӨДРӨӨС 05-Р САРЫН 15-НИЙ ӨДӨР | | | | | | |
| 1 | 3-р ээлж | Автомат Кропны тос | Литр | 383 | 8,300 | 3,178,900 |
| 2 | | Бензин масло | Литр | 1,034 | 5,950 | 6,152,300 |
| 3 | | Дизель масло | Литр | 450 | 7,750 | 3,487,500 |
| 4 | | Супер ТАП | Литр | 784 | 9,400 | 7,369,600 |
| 5 | | Делевол | Литр | 115 | 14,850 | 1,707,750 |
| 6 | | Солидол | Литр | 235 | 4,750 | 1,116,250 |
| 7 | | Тормозны шингэн | Литр | 132 | 4,300 | 567,600 |
| 8 | | Тосол | Литр | 1,031 | 2,400 | 2,474,400 |
| 9 | | Гидрийн шингэн | Литр | 181 | 3,200 | 579,200 |
| 10 | | Литол | Литр | 50 | 7,500 | 375,000 |
| Дүн: | | | | | | 27,008,500 |
| 2018 ОНЫ 05-Р САРЫН 15-НИЙ ӨДРӨӨС 08-Р САРЫН 15-НИЙ ӨДӨР | | | | | | |
| 1 | 4-р ээлж | Автомат Кропны тос | Литр | 384.0 | 8,300 | 3,187,200.00 |
| 2 | | Бензин масло | Литр | 1,033.0 | 5,950 | 6,146,350.00 |
| 3 | | Дизель масло | Литр | 450.0 | 7,750 | 3,487,500.00 |
| 4 | | Супер ТАП | Литр | 783.0 | 9,400 | 7,360,200.00 |
| 5 | | Делевол | Литр | 113.0 | 14,850 | 1,678,050.00 |
| 6 | | Солидол | Литр | 233.0 | 4,750 | 1,106,750.00 |
| 7 | | Тормозны шингэн | Литр | 130.0 | 4,300 | 559,000.00 |
| 8 | | Тосол | Литр | 1,032.0 | 2,400 | 2,476,800.00 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 9 | | Гидрийн шингэн | Литр | 181.0 | 3,200 | 579,200.00 |
| 10 | | Литол | Литр | 50.0 | 7,500 | 375,000.00 |
| Дүн: | | | | | | 26,956,050.00 |
| **Нийт дүн:** | | | | | | **107,981,550.00** |

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

"ПЕТРОСТАР" ХХКОМПАНИ